

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 08 дугаар сарын 01-ны өдөр

ТУЗТ 15/2022

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2022 оны хувьцаа
эзэмшигчдийн ээлжит бус хурал
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5, 60 дугаар зүйлийн 60.2, 60.3, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.6 дэх хэсгүүд, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэх хэсгүүд, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дэх хэсгүүд, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дэх хэсгүүд, 9 дүгээр зүйлийн 9.10.10, 9.10.11 дэх хэсгүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит бус хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 12.00 цагт Google Meet joining info Video call link: <https://meet.google.com/pmd-rsqc-pye> ашиглан, иргэний үнэмлэх, итгэмжлэлийг өөрийн зурагтай зэрэг камерт тулган баталгаажуулах байдлаар зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах этгээдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т. Золбоог томилсугай.
3. Энэ тогтоолын 1-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг 1 дүгээр хавсралтаар, хурлын хөтөлбөр, дэгийг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын танилцаж болох баримт материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарын загварыг 4 дүгээр хавсралтаар, тооллогын комиссын тогтоолын төслүүдийг 5, 6, 8-р хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлийг 7, 9-р хавсралтаар тус тус баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлэх өдрийг 2022 оны 08 дугаар сарын 04-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 08 дугаар сарын 20-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар, мэдээг 2022 оны 08 дугаар сарын 07-ний өдрөөр дахин зарлах өдрийг 15 өдрийн дараа байхаар тогтоож, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсны дагуу “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасан хэлбэр, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /П.Ням-Очир /-д даалгасугай.
6. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 17.00 цаг хүртэл ажлын өдрүүдэд ажлын 9-17 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, 40 50 мянгат, Бакула ринбучийн гудамж, 30-р байр,

10-р давхарт “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн байранд танилцуулах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс / П.Ням-Очир /-д даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокерын компаниар дамжуулан авч байгаа тохиолдолд уг саналын хуудсыг 2022 оны 09 дугаар сарын 09-ны өдрийн 16 цагаас өмнө байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зохион байгуулах комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
9. Хурал зохион байгуулах комиссын даргаар П.Ням-Очир, гишүүнээр Г. Төгөлдөр нарыг, Тооллогын комиссын даргаар Г. Төгөлдөр, гишүүнээр: П.Ням-Очир нарыг тус тус томилсугай.
10. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн материалыг 2022 оны 08-р сарын 10-ны өдрийн 15 цагаар тасалбар болгон хүлээн авсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Г.ЗОЛБОО/